

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН А.ЭНХ-АМГАЛАНГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. Байгууллагаас гаргаж буй эрх зүйн баримт бичиг, гэрээ, хэлэлцээр болон бусад баримт бичгийг хянах, боловсруулах, даргын тушаалаар баталсан журам, гэрээний нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан үүсгэх							
1.	Арга хэмжээ 1.1. Байгууллагын даргын батлан гаргах тушаал, шийдвэрийн төслийн эрх зүйн үндэслэл холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянах, санал тусгах	- Батлагдан гарсан тушаал, шийдвэрийн тоо. Хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 254, хүний нөөцийн чиглэлээр 122 нийт 376 тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэх санал тусган ажилласан.	03	100
2.	Арга хэмжээ 1.2. Иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, холбогдох хуульд нийцүүлэх арга хэмжээ авах	- Батлагдсан гэрээний тоо, Хэрэгжилтийн хувь	-	100	Бусдаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж гэрээ хийгдсэн 9, хамтран ажиллах, үйлчилгээ үзүүлэх, нэмэлт зэрэг бусад гэрээ 6, нийт 15 гэрээний төслийг тус тус хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, бүртгэснээр байгууллагын дарга баталгаажуулсан.	03	100
3.	Арга хэмжээ 1.3.	Хэрэгжилтийн хувь	-	50	Байгууллагын даргын 2025 оны А/168 тушаалаар “Кибер	03	

Байгууллагын даргын тушаалаар баталсан нийтээр дагаж мөрдөх журам зааврыг улсын бүртгэлд бүртгүүлэх, дотооддоо хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, баяжуулах ажлыг зохион байгуулах

аюулгүй байдлын хангах журам", А/226 тушаалаар "Хяналтын улсын байцаагчийн ажиллах заавар"-ыг тус тус шинэчлэн баталж, А/231 тушаалаар "Ёс зүй зөвлөлийн ажиллах журам"-ыг хүчингүй болгож, А252 тушаалаар Дотоод хяналт шалгалтын журамд нэмэлт, өөрчлөлт тус тус оруулсанг бүртгэж, тайлант хугацаанд өөрчлөлтийн бүртгэлийг бүрэн хөтөлсөн.

Мөн Гадаадын иргэн, харьяатын газрын цахим хаягийн <https://immigration.gov.mn/mn/legal/> эрх зүйн мэдээллийн хэсгээр иргэд үйлчлүүлэх, ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг англи, орос, солонгос, хятад, япон 5 хэл дээр, уг хуулийг дагалдан гарсан "Монгол Улсын виз олгох журам", "Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам", "Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам"-ыг тус тус хятад, солонгос хэлнээ хөрвүүлэн цахим хуудасны "Хууль эрх зүй" цэсэд

					байршуулж, гадаадын иргэний үйлчилгээ авах эрхийг хангаж байна.		
					Одоогоор байгууллагын хуулийн сан https://legal-efwpb.app.mcloud.gov.mn/ цахим хаягт Эрх зүйн актын лавлагаа 5, Засгийн газрын тогтоол 15, Төрийн мэдээлэл 68, Иргэд визгүй зорчих орны лавлагаа 77, Сайдын тушаал 27, Хууль бусаар байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай хэлэлцээр 1, Монгол Улсын нэгдсэн орсон олон талт гэрээ 7, Төрийн бусад байгууллага 3, Албан даалгавар 7, Хилийн боомтын дэглэмийн тухай гэрээ 4, ГИХГ-ын даргын баталсан журам нийтээр дагаж мөрдөх 4, дотогш чиглэсэн 76, хамтран ажиллах 20, Мэдээлэл засварлах маягт 2, Хууль 28, Хичээл гарын авлага 2 нийт 18 төрлийн дэд системд 444 хууль, журам, гэрээ, бусад зохицуулалтын шинжтэй эрх зүйн баримт бичгүүдийг бүртгэж, баяжилт, хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна.		
Зорилт 2. Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хууль тогтоомжид дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, шинэчлэх, байгууллагыг шүүх хуулийн байгууллагад төлөөлөх							
4.	Арга хэмжээ 2.1. Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг	Хэрэгжилтийн хувь.	-	50		03	

	боловсронгуй болгох, зөрчил, давхардал, хийдлийг арилгах зорилгоор судалгаа шинжилгээ хийх, холбогдох төсөл боловсруулах, нэмэлт өөрчлөлтийн оруулах ажлыг зохион байгуулах						
5.	Арга хэмжээ 2.2. Монгол Улсын хууль, УИХ, ЗГ-ын тогтоол, хууль зүйн болон бусад салбарын сайдын тушаалаар батлах шийдвэрийн төсөлд байгууллагын зүгээс тусгах санал боловсруулж, холбогдох нэгжээс саналыг авч, удирдлагад танилцуулан шийдвэрлэх	Ирүүлсэн албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	-	100	Хуулийн төсөлд 2 удаа санал хүргүүлсэн. Үүнд: Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөл, Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тус тус санал хүргүүлсэн бөгөөд Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь энэ оны 04 дүгээр сарын 09-ний өдөр lawforum.parliament.mn цахим хуудасны “боловсруулж буй төслүүд” цэсэд байршсан байна. Мөн Засгийн газрын тогтоолын төсөлд 2, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төсөлд 1, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн журмын төсөлд 1 удаа буюу дээд шатны байгууллагаас ирүүлсэн журмын төсөлд нийт 4 удаа санал боловсруулж, удирдлагад танилцуулан, хүргүүлсэн.	03	100
6.	Арга хэмжээ 2.3. Бүх шатны шүүхийн хэрэг, маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллаж, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан оролцох	- Шүүхэд төлөөлсөн тоо, Хэрэгжилтийн хувь	-	100	Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д зааснаар Бүгд Найрамдах Сьерро Леон Улсын нэр бүхий 7 иргэнд гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн өгсөн гарах сануулгыг хууль бусад тооцуулахаар гаргасан нэхэмжлэлтэй шүүх хуралд байгууллагыг төлөөлөн	03	100

					оролцож, шүүгчийн шийдвэр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан үр дүн гарсан.		
Зорилт 3. Албан хаагчдыг эрх зүйн мэдээллээр хангах, эрх зүйн зөвөлгөө өгөх, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх							
7.	Арга хэмжээ 3.1. Хуульчийн Про Боно 2025 өдөрлөгт байгууллагыг төлөөлөн оролцох, мэргэжил, удирдлага зохион байгуулалтаар хангах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	Хуульчдын холбооноос зохион байгуулдаг Хуульчийн про боно өдөрлөгт байгууллагын төвийн 4 албан хаагчдын хамт Сүхбаатарын талбайд иргэдэд зөвөлгөө мэдээлэл өгч ажилласан. Тус арга хэмжээг орон нутгийн хэмжээнд удирдлага зохион байгуулалтаар хангаж орон нутаг дахь нэгжийн албан хаагчид аймгуудынхаа төв талбай, Тамгын газруудад тус тус зохион байгуулсан.	03	100
8.	Арга хэмжээ 3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, тогтоомжийн дагуу баримт бичгийн стандарт, хэрэгжилтийг хангах	Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь	-	100	Бусад байгууллагад явж буй албан бичиг, өргөдөл гомдлын хариуг албан бичгийн стандарт, журмын дагуу боловсруулж хүргүүлсэн ба тайлант хугацаанд гаднаас 15 бичиг, 1 өргөдөл, гомдол ирснийг зөрчилгүй шийдвэрлэж ажилласан.	03	100
9.	Арга хэмжээ 3.3. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох.	- Оролцсон арга хэмжээний тоо Хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын 2025 оны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд газрын албан хаагчдын хамт оролцож хүрэл медаль, боулингийн тэмцээнд 4 дүгээр байрт тус тус шалгарсан. Сонирхлын бүлгүүдэд нэгдэж “Ууланд алхах бүлэг”-ийн буюу байгууллагын албан хаагчдын хамт ууланд тогтмол алхаж байна.	03	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хувь хүний хөгжлийн чиглэлийн цахим сургалтад хамрагдах	Гэрчилгээ авсан байх.	-	-	Сүүлийн хагас жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.		-

ТАЙЛАН ГАРГАСАН:

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)


..... /А.ЭНХ-АМГАЛАН/
(Нэр, гарын үсэг)

2025.06.10.

(Огноо)